

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 03 дугаар сарын 15

Дугаар 64

Улаанбаатар хот

“Баянзүрх дүүргийн Өмчийн ашиглалт,
үйлчилгээний төв” ОНӨААТҮГ газрыг өөрчлөн байгуулж,
дүрэмд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.12 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсгийг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын аравдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор Баянзүрх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх Баянзүрх дүүргийн өмчийн ашиглалт, үйлчилгээний төв орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг “Иргэд, олон нийтэд үйлчлэх төв” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар болгон өөрчлөн байгуулж, дүрмийг хавсралтаар баталсугай.

2.Тогтоол батлагдсантай холбогдуулан хуулийн этгээдийн мэдээллийн өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэхийг “Иргэд, олон нийтэд үйлчлэх төв” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирал (Б.Амарзаяа)-д даалгасугай.

3.Тогтоол батлагдсантай холбогдуулан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны А/45 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба (Ч.Мэндсайхан)-д даалгасугай.

ДАРГА

А.БАЯР